



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 5/16

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Баян-Адарга сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Нацагдорж нь ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул 2017 оны 03 сарын 06-ны өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээг цуцалж, үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

Хоёр. Сургуулийн захирлын ажлыг хүлээлцэх комисс томилон хүлээлцүүлэхийг Баян-Адарга сумын Засаг дарга /О.Лхагвадорж/-д даалгасугай.

Гурав. Л.Нацагдоржтой зохих хууль, журмын дагуу холбогдох тооцоог хийж дуусгахыг сургуулийн нягтлан бодогч /Б.Оргодол/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА